



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 09

Шарга

┌ Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдаан зарлах, хэлэлцэх асуудал  
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит IX хуралдааныг 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 10 цагт Соёлын төвд хуралдуулсугай.

2. Тус хуралдаанаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. Тэргүүлэгчдийн 2014 оны жилийн ажлын тайлан, 2015 оны төлөвлөгөө батлах тухай.

2. Засаг даргын 2014 оны үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт үр дүнг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх тухай.

3. Нутаг бэлчээр ашиглах журмын хэрэгжилт үр дүнг хэлэлцэх тухай.

4. Нохойн журмын хэрэгжилт үр дүнг хэлэлцэх тухай.

5. Байгаль орчны тасгийн 2014 оны жилийн ажлын тайлан. Байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг хэлэлцэж батлах.

6. Хил хамгаалах орон тооны бус Зөвлөлийн жилийн ажлын тайлан, батлах

7. "Хүний хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд хийсэн ажил, үр дүнг хэлэлцэх.

8. 2014 оны төсвийн гүйцэтгэл, Хөтөлбөр үйл ажиллагааны биелэлтийг дүгнэж, 2015 оны Төсвийн тодотголыг батлах.

9. 2015 онд ойгоос бэлтгэх Хэрэглээ, түлшний модны дээд хязгаар батлах.

Documents:/ith2015/Togtool/

10. Дэлгэр мөрний сав газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай.
11. Галт дулаан ОНӨААТҮГ-ын 2014 оны Санхүү, үр дүнгийн тайлан хэлэлцэх.
12. Гурван буман малын баяр болон Сум дундын эмнэлэгийн 80 жилийн ойн баярын тов, Баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг томилох.
3. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
4. Хуралд оруулах материалыг Хороодоор хэлэлцүүлж дүгнэлт гаргаж хуралдаанд танилцуулахыг Хороодын дарга нарт даалгасугай.
5. Хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдааны зар хүргэх ажлыг зохион байгуулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа /, Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Т.Мөнхбаяр/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ч.АЗБАЯР



ЦАГААН-УУЛ СУМЫН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ  
БЭЛТГЭЛ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хяналт тавих эзэн
1	Хуралдааны зар хүргэх, хуралдааны танхим бэлтгэх	2015.02.10- 2015.02.15	ЗДТГ-ын даргын түр орлон гүйцэтгэгч Т.Мөнхбаяр, ИТХ-ын нарийн бичгийн дарга Л.Сэрсмаа	ИТХ-ын дарга
2	Тэргүүлэгчдийн 2014 оны жилийн ажлын тайлан, 2015 оны төлөвлөгөө батлах	2015.02.10- 2015.02.24	ИТХ-ын дарга Ч.Азбаяр	ИТХ-ын Тэргүүлэгчид
3	Засаг даргын 2014 оны үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт үр дүнг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх	2015.02.10- 2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	ИТХ-ын хороодууд
4	Нутаг бэлчээр ашиглах журмын хэрэгжилт үр дүнг хэлэлцэх	2015.02.10- 2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр,	Байгаль орчин, газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо
5	Нохойн журмын хэрэгжилт үр дүнг хэлэлцэх	2015.02.10- 2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх, нийгмийн дэг журам мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан хороо
6	Байгаль орчны тасгийн 2014 оны жилийн ажлын тайлан, Байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг хэлэлцэж батлах.	2015.02.10- 2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Байгаль орчин, газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо
7	Хил хамгаалах орон тооны бус зөвлөлийн жилийн ажлын тайлан, батлах	2015.02.10- 2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх, нийгмийн дэг журам мэдээлэл, сургалт

				сурталчилгаа хариуцсан хороо
8	"Хүний хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд хийсэн ажил, үр дүнг хэлэлцэх	2015.02.10-2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	ИТХ-ын Тэргүүлэгчид
9	2014 оны төсвийн гүйцэтгэл, Хөтөлбөр үйл ажиллагааны биелэлтийг дүгнэж, 2015 оны Төсвийн тодотголыг батлах	2015.02.10-2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хороо
10	2015 онд ойгоос бэлтгэх Хэрэглээ, түлшний модны дээд хязгаар батлах	2015.02.10-2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Байгаль орчин, газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо
11	Дэлгэр мөрний сав газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай	2015.02.10-2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Байгаль орчин, газар зохион байгуулалт, бэлчээрийн менежмент хариуцсан хороо
12	Галт дулаан ОНӨААТҮГ-ын 2014 оны Санхүү, үр дүнгийн тайлан хэлэлцэх	2015.02.10-2015.02.24	ИТХ-ын дарга Ч.Азбаяр	Эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан хороо
13	Гурван буман малын баяр болон Сум дундын эмнэлэгийн 80 жилийн ойн баярын тов, Баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдүүнийг томилох	2015.02.10-2015.02.24	Засаг дарга Д.Түмэнбаяр	Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан, сэргийлэх, нийгмийн дэг журам мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан хороо